

## ЗҮҮН АЗИЙН ШИНЭ РЕГИОНАЛИЗМ БА МОНГОЛ УЛС

*С.Дашцэвэл\**

Монгол улс өнөөгийн даяарчлал, бүс нутгийн интеграцчилалын үйл явц өрнөж буй нөхцөлд хэрхэвч ганцаар байж болохгүй бөгөөд аль нэг бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож гэмээ нь бусдын хөгжлөөс хол хоцрохгүй байх боломжтой. Иймээс Монгол улс Ази Номхон далайн бүс нутаг руу илүү шадарлаж, энэ бүсийн хамтын ажиллагаанд түлхүү оролцох чиглэлийг барьдаг.

Эдүгээ зөвхөн Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаанд оролцох тухай ярих биш бас Зүүн Азийн шинэ регионализмд хэрхэн яаж хамрагдах тухай бодох, ярих цаг болоод байна. Иймд Зүүн Азийн шинэ регионализм буюу АСЕАН+3-ийн хамтын ажиллагааны талаар уншигч танд товч боловч танилцуулья.

### **1. Зүүн Азийн шинэ регионализмын эхлэл**

Зүүн Азийн бүс нутагт эдүгээ АСЕАН+3 хэмээх хамтын ажиллагааны шинэ үйл явц бүрэлдэн төлөвшиж байна. Үүнд АСЕАН-ы гишүүн 10 орон дээр Зүүн Азийн нөлөө бүхий 3 орон (Хятад, Япон, БНСУ) нийлж байгаа юм. Эдгээр улс орнууд газар нутгийн хувьд Номхон далайн зүүн эргийг эмжсэн байршилтай учир “Зүүн Азийн тал дугуй” гэж нэрлэгдэх нь бий. Энэ тал дугуйд орших орнууд ХХ зууны II хагасаас эрчимтэй хөгжих замд орохдоо түүхэн хөгжлийн гадаад дотоод нөхцөл байдлаас шалтгаалан нэг нь нөгөөдөө хөгжлийн аятай нөхцөл бүрдүүлж ирсэн түүхтэй. Зүүн Азийн орнуудын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт хэдэн арван жил үргэлжилсэн бөгөөд 80, 90-ээд онд улам идэвхжсэн юм. Хөрөнгө оруулалтын салбарт Япон улс тэргүүлж 60, 70-аад оноос үйлдвэрлэлийн сүлжээг эхлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Тухайлбал 70-аад онд Японы хөрөнгө оруулалт хөрш зэргэлдээх орнууд руугаа урсч, Япон улсын үйлдвэрлэлийн нэг хэсэг хил залгаа орнуудад шилжсэн бол 80-аад онд шинээр аж үйлдвэржсэн орнууд бий болж 80-аад оны эцсээр Япон болон шинээр аж үйлдвэржсэн “Барууд” АСЕАН-ы орнууд руу үйлдвэрлэлээ шилжүүлж дараа нь Хятад руу мөн урсгал орж эхлэв. 1995 он гэхэд Зүүн Азийн хөгжиж буй бүх орнууд дахь хөрөнгө оруулалтын 50% нь тус бүсийн доторх Япон болон “Бар” орнуудаас оржээ. Үүнийг дагалдаж Зүүн Азийн орнууд хоорондын худалдааны эргэлт үлэмж өсөв.

\*С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Ийнхүү Зүүн Азийн орнуудын үйлдвэрлэл худалдааны сүлжээ эдийн засгийн өсөлтийн эрэлт хэрэгцээний дагуу аяндаа бий болсон бөгөөд энэ нь Зүүн Азийн шинэ регионализмын аятай хөрсийг бий болгосон байна. Нөгөө талаар 90-ээд оны дунд үеэс эхэлсэн Зүүн Азийн санхүүгийн хямрал эдгээр орнуудад олон зүйлийг ойлгуулав.

1) Юуны өмнө тэдгээр орны эдийн засаг-санхүүгийн харилцан хамаарлыг гүнзгий мэдрүүлэв. АСЕАН-ы зарим оронд санхүүгийн хямрал эхэлмэгц тэр нь Япон, Солонгосын эдийн засаг-санхүүд шууд нөлөөлсөн бөгөөд Японы санхүүгийн дэмжлэггүйгээр хямралаас гарах аргагүй нь АСЕАН-ы орнуудад тодорхой байв. Тэрчлэн Хятад улс мөнгөнийхөө ханшийг тогтвортой барьж, БНСУ-ын эдийн засаг түргэн сэргэсэн зэрэг хүчин зүйлс АСЕАН-ы эдийн засаг сэргэхэд шууд нөлөөлөв. АСЕАН-ы эдийн засаг сэргэж байгаа нь эргээд Япон, Солонгос, Хятадын эдийн засагт эерэгээр нөлөөлж байна.

2) Аяндаа үүссэн эдийн засаг-үйлдвэрлэлийн сүлжээ нь хөгжлийнхөө явцад зах зээлийн өрсөлдөөний улмаас ургаж гарсан олон асуудалтай тулгарч байгаа нь харагдав. Эдгээр асуудлыг аль нэг орны эрх ашгийн үүднээс биш, бүх улсуудын нийтлэг эрх ашгийн үүднээс шийдэхэд хамтын хүчин чармайлтыг шаардав.

Ийнхүү эдийн засгийн хөгжлийн динамик хуулиар аяндаа бий болсон (ямар нэг бодлогоор зохицуулж бий болгоогүй) эдийн засаг зах зээлийн нягт хамаарал нь Зүүн Азийн бүлэг улсуудыг дуртай ч, дургүй ч эдийн засаг-санхүүгийн үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах олон талт механизм бий болгох зам руу түлхжээ. Энэ нь Зүүн Азийн орнуудад өөрсдийгөө алив эрсдлээс хамгаалах, улмаар даяарчлал, регионализмын нөхцөлд өрсөлдөх чадвараа дээшлүүлж Ази, Номхон далайн бүс нутагт байр сууриа бэхжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

Үүнээс гадна 90-ээд оны санхүүгийн хямралаас авсан нэгэн сургамж бол эдийн засаг, санхүүгийн хүнд нөхцөлд АНУ-д түшиглэсэн барууны санхүүгийн тусламжинд хэт найдаж болохгүй гэдэг нь ч тодорхой харагдав. Өөрөөр хэлбэл АПЕК, АСЕМ-ын зүгээс туслах боломж харагдаагүй бөгөөд тэр үед Олон Улсын Валютын Сан (ОВУС) өөрсдийн болзлыг тулгах нь ихэссэн зэрэг гаж үзэгдэл мэдрэгдэв. Түүнчлэн АПЕК-ын үйл ажиллагаа албан ёсны болж АНУ-ын зүгээс түүнийг либералчилахыг яаруулах болсон явдал Зүүн Азийнхныг түгшээж эхэлсэн байна. Энэ бүхэн нь Зүүн Азийн шинэ регионализм үүсч үйл ажиллагаа нь идэвхжихэд нөлөөлжээ. Нөгөө талаар олон

улсын бусад байгууллага болон олон талт хамтын ажиллагааны механизмд оролцох Зүүн Азийн орнуудын нэр хүнд, нөлөөг ихэсгэх нь өнөө үед мөн л чухал болоод байна. Жишээ нь: ОУВС, ДХБ, АПЕК зэрэг эдийн засгийн олон талт байгууллагуудад оролцож буй АНУ-ын арга ажиллагааны өмнө Азийн орнууд үнэндээ хүчин мөхөс байгаа билээ. Үүнд хүчний тэнцвэр бий болгох, өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засгийн талбарт эн тэнцүү тоглогч болох хүсэл эрмэлзлэл шинэ регионализмд хамрагдагч эдгээр орнуудад байгаа нь тодорхой.

Зүүн Азийн орнуудын эдийн засаг, худалдааны хэмжээ АНУ, Европын холбооноос дутах юмгүй атлаа<sup>1</sup> нэгдсэн зохион байгуулалт сул байгаа нь эдийн засгийн олон талт байгууллагуудад тэдний дуу хоолой үл сонсогдом байгааг зарим судлаачид цохон тэмдэглэж, хэрвээ Зүүн Азийн регионализм хүчтэй болох аваас АНУ, ЕХ, Зүүн Азийн эдийн засгийн томоохон гурвалжин бий болно хэмээн үзэж байна.<sup>2</sup>

Зүүн Азийн орнууд олон талт хамтын механизм бий болгохын тулд багагүй зам туулав. Тухайлбал Зүүн Азийн эдийн засгийн бүлэг (ЕАЕС) байгуулах тухай 1990 оны Малайзын санал амжилт олсонгүй. Дараа нь 1995 онд АСЕАН-ы орнуудын удирдагчид Банкгогт чуулж нэгэн санаачлага гаргав. Энэ нь АСЕАН-ы 10 орон болон Хятад, БНСУ, Японы удирдлагуудын уулзалт хийх санал байв. Чухамхүү энэ үеэс АСЕАН+3-ын хамтын ажиллагаа бий болох анхны шав тавигджээ.

1997 оны эцсээр Малайзын Куала-Лампур хотод АСЕАН-ы орнуудын удирдлага Япон, Хятад, БНСУ-ын удирдлагатай анхны хамтарсан уулзалт зохион байгуулав. Энэхүү уулзалтаар АСЕАН+3-ын хамтын ажиллагааны хөтөлбөр баталжээ. Энэ хөтөлбөрийн дагуу хоёр дахь уулзалтыг 1998 онд АСЕАН-ы орнуудын дээд уулзалтын үеэр Ханойд хийсэн бөгөөд дараагийн уулзалт Филиппиний Манил хотноо 1999 оны эцсээр болж Зүүн Азийн хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдлийг батлав. Хамтарсан мэдэгдэлд АСЕАН+3-ын үйл ажиллагааны үндсэн зарчмыг баталж хамтын ажиллагааны гол салбаруудыг тодорхойлжээ. Үүнд юуны өмнө АСЕАН+3-ын хамтын ажиллагаа нь энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим, 1976 оны Балийн гэрээний зарчим, олон улсын хуулийг мөрдлөг болгох ажээ. Зүүн Азийн хамтын ажиллагаа нь худалдаа, хөрөнгө оруулалт, мөнгө санхүү, шинжлэх ухаан-технологи, үйлдвэр-хөдөө аж ахуйн салбарыг хамарна хэмээн заав.<sup>3</sup>

Түүнийг хэрэгжүүлэх механизм нь жил тутмын дээд уулзалт, яамдын сайд нарын болон салбарын мэргэжилтнүүдийн уулзалт ажээ.

Өнгөрсөн хугацаанд АСЕАН+3-ын хамтын ажиллагааны механизм үндсэндээ төлөвшиж 2001, 2002, 2003 онд дээд удирдлагын болон салбарын сайд нар, мэргэжилтний уулзалт удаа дараа болж бодлого чиглэлээ боловсронгуй болгосоор байна.

## **2. АСЕАН+3-ын хамтын ажиллагаа**

АСЕАН+3-ын хамтын ажиллагаа эдүгээ эдийн засаг, санхүүгийн салбарт голлон төвлөрч байна.

АСЕАН+3-ын орнууд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ юуны өмнө худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, чингэхдээ аль болох шинэ технологи бие биендээ шилжүүлэх ялангуяа мэдээллийн техник технологийн салбарт хамтран ажиллахыг онцлон үзэх, өөр хоорондоо интернет худалдааг хөгжүүлэх, худалдааг нээлттэй байлгаж, түүнд хөгжингүй орнууд болон эдийн засгийн бүсүүдийг хамруулах, Зүүн Ази дахь хүний хөгжлийн нөөцийг хөгжүүлэхэд хамтын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг хүчтэй болгох, олон улсын болон бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд үйл ажиллагаагаа зохицуулж хамтран ажиллахаар тохиролцон ажиллаж байна. <sup>4</sup>

Одоо Зүүн Азийн орнууд мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах, хоцрогдонгуй хөгжилтэй зарим орны жижиг дунд үйлдвэрийн чадварыг нэмэгдүүлэх замаар тэдний эдийн засгийн өсөлтийг ойртуулах чиглэлээр хэд хэдэн томоохон төсөл хэрэгжүүлж эхлээд байна. БНСУ-ын санаачлагаар Зүүн Азийн бизнес эрхлэгчдийн зөвлөл байгуулагдаж хамтын ажиллагааны олон салбарт хөрөнгө оруулж эхэлжээ. Эдийн засгийн чухал салбаруудад хөрөнгө оруулах, төсөл хэрэгжүүлэх хамтын сангууд бий болж байна. Эдгээр сангууд хилийн худалдааны чөлөөт бүс, экспорт-үйлдвэрлэлийн паркуудыг байгуулах, томоохон магистрал зам барилгуудад хөрөнгө оруулахад чиглэгдэж байна. Тухайлбал Куньмин-Сингапурыг холбосон 4300-5500 км урт төмөр замын томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. 2000-2020 онд тавьж дуусгах энэ төмөр зам нь Өмнөд Хятадын Куньмин хотоос Бирм, Тайланд, Лаос, Вьетнам, Малайзыг дайран Сингапурт хүрэх юм. 2 тэрбум долларын хөрөнгө оруулалттай энэ хөтөлбөр 55 том жижиг төслөөс бүрдэх бөгөөд Зүүн Өмнөд Азийг нэвт холбосон авто зам болон усан замын боомтууд баригдах аж. <sup>5</sup>

АСЕАН+3-ын орнууд гадаад худалдааны хувьд харьцангуй бие даасан бодлоготой бөгөөд ДХБ, АПЕК-ын хүрээнд худалдааны олон талт харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Үүний хамт Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс (ЕАФТА) бий болгох боломжийг Зүүн Азийн судалгааны байгууллага тусгайлан судалж хөтөлбөр боловсруулж байна. Худалдааны хамтын ажиллагаа нь эхний шатанд гааль татварын давуу нөхцөл бүрдүүлж чөлөөт худалдааг дэмжих замаар хөгжиж байна. Одоо Япон-Сингапурын хооронд, Япон-БНСУ-ын хооронд, мөн Хятад-АСЕАН-ы хооронд худалдааны чөлөөт бүсүүд байгуулахаар бэлтгэл ажил хийж байна. Энэ нь бүс нутгийн худалдаа өргөжих нэн таатай нөхцөл бүрдэнэ гэсэн үг юм.

АСЕАН+3-ын мөнгө санхүүгийн салбар дахь хамтын ажиллагаа харьцангуй түргэн хөгжиж байна. Өнгөрсөн хугацаанд Сангийн сайд нарын уулзалт, Азийн хөгжлийн банктай хамтарсан уулзалт удаа дараа хийжээ. АСЕАН+3-ын сайд нарын уулзалт жилд нэг удаа болох боловч Санхүү эдийн засгийн сайд нар шаардлагатай гэсэн үедээ уулзалдах болов. Азийн эдгээр орнууд юуны өмнө банк санхүүгийн туршлагаа солилцож, бие биенээс суралцах ажлаа эрчимжүүлж байна. АСЕАН+3-ын банкны удирдлагууд 2 жил тутам уулзаж мөнгө санхүүгийн салбарын хамтын ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх болжээ.

АСЕАН+3-ын удирдлага сүүлийн үед Азийн Валютын Сан (АМФ) байгуулах, Японы иенийг олон улсын валют болгох чиглэлээр ажиллах санаачлагыг дэвшүүлж байна. <sup>6</sup> Мөн санхүүгийн аливаа хямралыг таслан зогсоох зорилгоор мөнгө санхүүгийн дэмжлэг харилцан үзүүлж байх тогтолцоог бий болгох хөтөлбөрийг баталжээ. <sup>7</sup> Үүний тулд юуны өмнө АСЕАН+3-ын хамтын сан (1 тэрбум орчим ам.доллар) байгуулав. Мөн гаднаас орж ирэх богино хугацаат хөрөнгө оруулалтын урсгалыг хянаж байх, түүний сөрөг нөлөөг хязгаарлах, түүнтэй тэмцэх зохистой аргуудыг хамтран хайх болжээ. АСЕАН+3-ын хооронд валютын арилжааны тогтолцоог боловсронгуй болгож солилцоог өргөжүүлэх ажил нэн ахицтай байна. Юуны өмнө хоёр талын валютын арилжааны сангууд бий болж байна. Тухайлбал Япон-Тайландын 3 тэрбум ам.долларын нөөц бүхий сан, Япон-БНСУ-ын 2 тэрбум ам.долларын, Япон-Малайзын 1 тэрбум ам.долларын гэх мэт сангууд нэгэнт байгуулагдаж, энэ чиглэлээр хоёр талын хэлэлцээрүүд ихэнх гол улсуудын хооронд хийгдэж байна. <sup>8</sup> Мөн БНСУ-Тайланд-Хятад гурвын хооронд болон Хятад-Тайландын хооронд санхүүгийн дэмжлэг харилцан үзүүлэх гэрээ хийгджээ. <sup>9</sup>

### 3. Зарим бэрхшээл

Зүүн Азийн эдийн засгийн интеграцчилал хэрэгжихэд зарим бэрхшээл бий. 1) Юуны өмнө тус бүсийн орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшин харилцан адилгүй, зарим нь зах зээлийн эдийн засаг хөгжсөн, зарим нь төвлөрсөн эдийн засгаас зах зээлд шилжих шатанд яваа. Мөн зарим нь таваарын аж ахуйг дөнгөж хөгжүүлж буй бөгөөд эдийн засгийн хувьд өөрөө өөрийгөө аргацаах төдий түвшинд гэх мэт. 2) Энэ бүсийн орнуудын ихэнх нь хөгжиж буй орнууд учраас хөрөнгө оруулалт, зээл тусламж, худалдаа, технологи зэрэг олон салбарт бие биенээс өрсөх хандлагатай. Ялангуяа зарим салбарын үйлдвэрлэл нэн ижил төстэй учраас зах зээлийн өрсөлдөөнд бие биендээ аюул учруулж байна. Тухайлбал, цахилгаан, электрон барааны үйлдвэрлэл Хятадад нэн эрчимтэй хөгжиж эхэлмэгц Малайз, Тайланд, Филиппин зэрэг орны ижил төрлийн үйлдвэрлэлд аюул учираад байгаа билээ.

Одоохондоо АСЕАН-ы улсууд Зүүн Азийн хамтын ажиллагааны бүсийг бүрэн утгаар нь бий болгох эрмэлзлэлтэй боловч хөгжлийн түвшин ижил биш учраас зарим болгоомжлол байсаар байна. Тухайлбал АСЕАН+3 гэсэн бүтцийг тодорхой хугацаанд хадгалах нь чухал хэмээн Малайзын Засгийн газар үзэж байна. Учир нь АСЕАН-ы 10 орон тус тусдаа энэхүү хамтын ажиллагаанд оролцвоос Хятад, Япон мэтийн том эдийн засгуудтай өрсөлдөх боломж хомс юм. Нөгөө талаар АСЕАН хэмээх байгууллагын үүрэг, байр суурь үгүй болж, АСЕАН-ы орнуудын эрх ашигт хохирол учрах талтай хэмээн болгоомжилж байна. Иймд юуны өмнө АСЕАН-ыг эдийн засгийн хувьд бэхжүүлж байж сая Япон, Хятад, БНСУ-тай бүрэн интеграцид орох бодолтой байна.

Зүүн Азийн шинэ регионализм нь эдийн засгийн өрсөлдөөнд байр сууриа бэхжүүлэх гэсэн тухайн орнуудын хүсэл эрмэлзлэлийн илэрхийлэл юм. Харин улс төр, аюулгүйн салбарт энэ бүсийн хамтын ажиллагаа ирээдүй багатай юм хэмээн судачид үзэж байна.<sup>10</sup> Учир нь орон тус бүрийн улс төр, аюулгүйн бодлого баахан өөр бөгөөд харилцан ойлголцож зохицоход тодорхой цаг хугацаа шаардлагатай. Улс орон бүр өөрийн үндэсний аюулгүй байдал, төрийн бүрэн эрхээ хадгалан бэхжүүлэх зорилгын үүднээс их гүрнүүдтэй харилцах төрийн бодлого нь ижил биш, олон улсын асуудалд өөр өөр байр сууринаас ханддаг. Эдүгээ энэ талаар нийтлэг нэг байр суурьтай болох орчин нөхцөл хараахан бүрдээгүй байна. Энэ нь олон улсын дэг журам төдийлөн цэгцрээгүй, их гүрнүүдийн ашиг сонирхлын тэнцвэр Ази Номхон далайн бүс нутагт хараахан тогтворжоогүй байгаатай холбоотой нарийн төвөгтэй үйл явц юм.

#### 4. Хэгийн төлөв ба Монгол улс

Хэдийгээр иймэрхүү бэрхшээл ажиглагдаж байгаа ч гэсэн Зүүн Ази дахь эдгээр 13 оронд эдийн засаг, мөнгө санхүү, худалдааны нягт хамтын ажиллагаа нэн шаардлагатайг өнөөгийн даяарчлалын орчин шаардах боллоо. Тийм ч учраас Зүүн Азийн хамтын ажиллагаа эргэлт буцалтгүй бөгөөд улам гүнзгийрэн хөгжиж байна. Эцсийн зорилго нь Зүүн Азийн чөлөөт бүс бүхий хамтын нийгэмлэг (Европын Холбоо мэт) болох чиглэлтэй нь ч тодорхой. Энэ үйл явцын эхний суурь АСЕАН+3 гэсэн хэлбэрээр бат бэх тавигдаж, Ази Номхон далайн бүс нутагт Зүүн Азийн эдийн засаг-санхүүгийн томоохон төв бий болох үйл явц эрчимтэй өрнөж байна.

Монгол улс Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаанд оролцохыг ихэд мэрийдэг. Гэтэл Зүүн Хойд Ази дахь хамтын ажиллагаа ялангуяа олон талт хамтын ажиллагааны явц төдийлөн урагш ахихгүй байна. 1995 онд албан ёсоор эхэлсэн Түмэн голыг нээж ашиглах хөтөлбөр зөвхөн ачаа тээвэрлэх, нэвтрүүлэх, хот байгуулалт ба аялал жуулчлалыг хөгжүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байна.<sup>11</sup> Учир нь оролцогч орнуудын хөрөнгийн чадвар хэт их зөрүүтэй, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн бүтэц байхгүй, төв засгийн газруудын урагш хөтлөх олон талт механизм илт дутагдалтай гэх мэт олон шалтгаан байсаар байна. Гэтэл энэ хооронд Зүүн Азид АСЕАН+3 хэмээх бүлэг улсуудын эдийн засаг-санхүүгийн хамтын ажиллагааны тодорхой хөтөлбөрүүд хэрэгжиж АСЕАН-Хятадын, Япон-Солонгосын, Япон-Хятадын, Солонгос-Сингапурын гэх мэт худалдааны чөлөөт бүсүүд үүсч, хөрөнгө оруулалт-хөгжлийн нэгдсэн сангууд байгуулагдаж төв засгийн газруудын яриа хэлэлцээний байнгын механизм хүчтэй үйлчилж эхлээд байгааг бид харж байна.

Монгол улс АСЕАН+3-ын 13 оронтой хоёр талын уламжлалт харилцаатай. Ялангуяа Хятад, Солонгос, Японтой хоёр талын харилцаа муугүй хөгжиж байгаа. АСЕАН-ы орнууд ба эдгээр 3 орны хоорондын харилцаа нэн дээр үеэс нягт шүтэлцээтэй хөгжиж одоо салгахын аргагүй уялдаа холбоотой болсон бөгөөд нэг эдийн засаг нь доголдох аваас нөгөөдөө хүчтэй нөлөөлөх хэмжээнд хүрснийг 90-ээд оны Зүүн Азийн санхүүгийн хямрал харуулсан. Харин Монгол улсын санхүү эдийн засаг унахад тэдэнд нөлөөлөхгүй жишээтэй. Монгол улсын эдийн засаг нэн бага тул бүс нутгийн интеграцид оролцох өөрийн гэсэн арга замыг олох хэрэгтэй билээ. Юуны өмнө Зүүн Хойд Азийн төдийгүй Зүүн Азийн интеграцчилалд оролцох зорилтыг тууштай баримтлах,

түүнийг хэрэгжүүлэх үе шатуудыг тодорхойлох нь чухал санагдана. Үүнд 1) Улс орныхоо эдийн засгийн чадавхийг өсгөх 2) Давуу талаа ашиглан дэлхийн зах зээлд өөрийн гэсэн “лангуу”-тай байх түүнийгээ байнга хадгалан баяжуулах 3) Хил залгаа орнуудтайгаа эдийн засгийн болон худалдааны жижиг чөлөөт бүсүүдэд нэгдэх 4) АСЕАН-ы орнуудын зарим хөтөлбөрт тухайлбал Сингапур Малайзаас АСЕАН-ы гишүүн бусад орнуудад үзүүлж буй боловсрол мэдээллийн технологийн салбар дахь хамтын төсөл, Тайландаас хэрэгжүүлж буй хүний нөөцийн хөгжлийн төсөл зэрэгт оролцох гэх мэт шат дараалсан бодлого хэрэгжүүлж улмаар Зүүн Азийн интеграцчилалд дөхөж очих шаардлагатай мэт санагдана. Үүний тулд 1) Зүүн Азийн шинэ регионализмын үйл явцыг байнга анхааран судлах 2) Түүнд ойртох, нэгдэх ямар арга зам байгааг олох. Тэгэхдээ жижиг эдийн засгийн хувьд тэрхүү регионализмд хэрхэн эрсдэл багатай (уусч алга болохгүйгээр өөрийгөө авч үлдэх замаар) нэгдэж хамт зэрэгцэн хөгжих арга замыг олох нь чухал байна.



**Ашигласан материал**

1. Дэлхийн хүн амын 28,5%, ДНБ-ий 19,2%, худалдааны 20% оногдоно. Michal Wesley, The new East Asian Regionalism.. Challenges and opportunities, The Asia-Australia Paper, The Asia-Australia Institute, N-3, June 2000, P.4
2. Fred Bergsten, “Гурван талт дэлхий ертөнц өөд”, Economist, 21/7/2000
3. Joint statement on East Asia Cooperation, Manila, Philippines 28 November 1999, Asian Documents series 1998-1999, the ASEAN secretariat, 1999. pp. 34
4. Tran Khanh, lien ket Asian trong boi canh toan cau hoa, Hanoi, 2002 tr 180
5. Pham Nguyen Long, The ky XXI, vi the cua ASEAN o vong cung Dong A. New environment in East Asia, p.44
6. Зүүн Азийн валютын нөөц АНУ, ЕХ-оос үлэмж их. Зүүн Азийнх 668 тэрбум ам.долл бол АНУ 71 тэрбум ам.долл, ЕХ 380 ам.доллар. Тийм учраас бусдын хараат бус байх бүрэн боломжтой хэмээн үзэж буй.
7. Tran Khanh, lien ket Asian trong boi canh toan cau hoa, Hanoi, 2002 tr 182
8. Thoi bao kinh te Viet Nam, So 65, 30.5.2001
9. Мөн тэнд, tr.15
10. Ton Khanh Linh, Nhung thuan Loi va thach thuc doi voi hop tac Dong A, Tap chi nghien suu, quoc te, 2001, N3, tr.35
11. “Олон улс судлал” сэтгүүл, УБ, 2002 №2 95-р тал